

# Калифорнийн 2020 оны Ерөнхий Сонгуульд саналаа хэрхэн өгөх вэ

## Бэлдээрэй

Хэрвээ та санал өгөхөөр бүртгүүлчихсэн бол та [voterstatus.sos.ca.gov](http://voterstatus.sos.ca.gov) руу орж өөрийн бүх мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгаарай. Өөрийн хаяг, цахим шуудангийн хаягийг шалгаад орчуулсан сонгуулийн материалуудыг хүлээн авахыг хүсэж байгаа эсэхээ илэрхийлээрэй.

Хэрвээ та бүртгүүлээгүй бол та онлайнаар [registertovote.ca.gov](http://registertovote.ca.gov) сайтад онлайнаар, Авто Тээврийн Газар, шуудангийн салбар, номын сан, орон нутгийн сонгуулийн газраас маягтыг аваарай. Хэрвээ та бүртгүүлэх өдрөөс хоцорсон бол та Сонгуулийн өдөр хүртэл, эсвэл тухайн өдөр бүртгүүлж болно.

## Гэрээсээ санал өгөх

Хэрвээ та аравдугаар сарын 19-ний өдөр гэхэд бүртгүүлсэн бол та саналын хуудсыг шуудангаар хүлээн авна. Саналын хуудсаа бөглөөд гарын үсэг зурж, огноо тавиад лацадсан эсэхээ нягтлаарай.



Та үүнийг **шуудангаар** буцааж болно. Шуудангийн хураамж төлөх шаардлагагүй! Арваннэгдүгээр сарын 3-ны өдөр дуусахаас өмнө түүнд шуудангийн тэмдэг тавьсан эсэхийг шалгаарай.

Та үүнийг каунтийн сонгуулийн газар, санал хураах газар юмуу санал хураах төв дээр **үлдээж болно**. Ихэнх каунти аравдугаар сарын эхээс эхлэн бэлэн гаргах хамгаалагдсан санал хураах хайрцаг ажиллуулна.



## Өөрийн биеэр очиж санал

Сонгууль явагдах өдөр бол **2020 оны арваннэгдүгээр сарын 3-ны мягмар гариг**. Санал хураалт **өглөөний 7 цагаас оройн 8 цагийн хооронд үргэлжилнэ**.

Та өөрийн санал өгөх газрыг эндээс хайж болно: [sos.ca.gov/elections/polling-place](http://sos.ca.gov/elections/polling-place).

Ихэнх каунт **2020 оны аравдугаар сарын 31-ний бямба гаригаас эхлэн биечлэн ирж санал өгөхийг санал болгодог** бөгөөд зарим каунтид биечлэн санал өгөх боломжийг урьдчилан зохион байгуулж болно. Орон нутгийхаа сонгуулийн албанаас лавлана уу.



Таныг урьдчилан санал өгөх байршил болон саналын хайрцгийг эндээс хайж болно: [caearlyvoting.sos.ca.gov](http://caearlyvoting.sos.ca.gov)

Энэ явцыг хялбаршуулахын тулд хэрвээ та саналын хуудсыг шуудангаар хүлээн авсан бол түүнийг буцаахын тулд авчиргахыг хичээгээрэй.